



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 24 өдөр

Дугаар А/369

Чингис хот

Урьдчилан сэргийлэх арга хэмжээг
эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Засгийн газрын 2020 оны 62, 64, 102 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 28 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавирусын халдвар /КОВИД-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд сунгасугай.

2. Коронавирусын халдвар /КОВИД-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх үүднээс амны хаалт зүүсэн иргэдэд үйлчлэхийг аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн хэвшлийн аж ахуй нэгж байгууллагын дарга, эрхлэгч, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3. Коронавирусын халдвар /КОВИД-19/ цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх шалгалтыг 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 09 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж, дүнг аймгийн Засаг дарга бөгөөд Онцгой комиссын даргад илтгэх хуудсаар танилцуулахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т үүрэг болгосугай.

4. Шуурхай штабыг байгуулж өдрийн 8 цагаар ажиллах бүрэлдэхүүнийг томилгоожуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт, нэгдсэн удирдлагаар хангаж мэдээ мэдээллийг нэгтгэн танилцуулж ажиллахыг Шуурхай штаб /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/-д даалгасугай.

5. Коронавирусын халдвар /КОВИД-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, тусгаарлах байрны бэлэн байдлыг хангаж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Баасандорж/, сумдын Засаг дарга, тосгоны захирагч нарт тус тус үүрэг болгосугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/, Шуурхай штабын дарга /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

2020